

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ ШААРДЛАГА, ЯПОН УЛСЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН СОЁЛООС СУРАЛЦАХ НЬ

У.ЗАГДЦЭСЭМ

ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний дэд ажилтан

Товч агуулга: Эдүгээ манай улс аж үйлдвэрлэлийн салбарын бүтцийн зохистой харьцааг богино хугацаанд сэргээж, эдийн засгийг төрөлжүүлэх шаардлагатай тулгарч буй бөгөөд эдийн засгийн өндөр хөгжилтэй орнуудын туршлагаас суралцах асуудал зүй ёсоор урган гарч байна.

Манай улстай дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр орны харилцаа 1990 оноос шинэ шатанд шилжиж, Иж бүрэн түншлэлийн харилцаа, Стратегийн түншлэлийн харилцаанд дэвшин, Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг анх түрүүнд байгуулсан Япон Улсын аж үйлдвэрийн туршлага, соёлоос суралцах нь үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд түлхэц өгч, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэхэд хувь нэмэр болох хүчин зүйл гэж үзэж байна.

Япон Улстай хөгжүүлж ирсэн соёлын хамтын ажиллагаа хоёр орны харилцааны хөгжил дэвшлийн түүхэн үйл явцтай уялдан цар хүрээ нь өргөжиж, агуулга нь гүнзгийрэн, шинэ чиг хандлагаар баяжсаар байна. Өнгөрсөн хугацаанд хоёр орны соёлын харилцааны салбарт шинээр төлөвшиж үр ашгаа өгч байгаа чиг хандлагад аж үйлдвэрийн соёл, компанийн соёлыг хамруулан үзэх боломжтой.

Түлхүүр үгс: Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх шаардлага, Монгол-Японы эдийн засгийн хамтын ажиллагаа, Япон Улсын аж үйлдвэрийн туршлага, соёл

Эдүгээ манай улсын эдийн засаг уул уурхайн бүтээгдэхүүний экспортод хэт түшиглэсэн¹ өрөөсгөл бүтэцтэй, аж үйлдвэрлэлийн бусад салбар хангалттай хөгжөөгүйн улмаас дэлхийн зах зээл дэх байгалийн баялгийн үнийн хэлбэлзлээс үүдэлтэй төсвийн алдагдалд орж, нийгэм, эдийн засаг хүндхэн сорилтуудтай тулгарсаар байгаа билээ. Мөн манай улсын

¹ Монгол Улс 2021 онд 9.25 тэрбум ам.долларын экспорт хийснээс 7.5 тэрбум ам.доллар буюу 81.3%-ийг эрдэс баялгийн бүтээгдэхүүн эзлэв. /Гаалийн ерөнхий газар, 2022.01 сар/

аж ахуйн нэгж байгууллагуудын 70 хувийг эзлэдэг жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд аж ахуйгаа эрхлэн явуулах мэдлэг чадвар, мэргэжилтэй боловсон хүчин дутмаг байгаа нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна. Эдийн засгийн хөдөлгөгч хүч болох жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх явдал нь аж үйлдвэрлэлийг төрөлжүүлэхэд ихээхэн хувь нэмэр болох талаар судлаачид дурдсаар байна. Иймд Монгол Улсын тогтвортой хөгжлийн төлөө уул уурхайн үйлдвэрлэлээс бусад тухайлбал, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, IT программ хангамж гэх мэт өндөр технологийн аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн бүтцийн зохистой харьцааг богино хугацаанд сэргээж, төрөлжүүлэх шаардлага тулгарч буй бөгөөд өндөр хөгжилтэй орнуудын туршлагаас суралцах асуудал зүй ёсоор урган гарч байна.

Монгол Улс, Япон Улсын хооронд 1972 онд дипломат харилцаа тогтоосон. Энэ харилцаа 1990 оноос шинэ шатанд шилжиж, Иж бүрэн түншлэлийн харилцаа, Стратегийн түншлэлийн харилцаанд дэвшин, Эдийн засгийн түншлэлийн харилцааны шатанд хүрч хөгжиж байна.

Япон Улстай хөгжүүлж ирсэн хамтын ажиллагаа хоёр орны харилцааны хөгжил дэвшлийн түүхэн үйл явцтай уялдан цар хүрээ нь өргөжиж, агуулга нь гүнзгийрэн, шинэ шинэ чиг хандлагаар баяжсаар байна. Тухайлбал, өнгөрсөн хугацаанд хоёр орны соёлын харилцааны салбарт шинээр төлөвшиж үр ашгаа өгч байгаа чиг хандлагад аж үйлдвэрийн соёл, компанийн соёлын /企業文化/ хамтын ажиллагааг хамруулан үзэх боломжтой.

Хоёр улсын аж үйлдвэрийн соёлын хамтын ажиллагааны хөгжлийг хоёр талын хооронд эдийн засгийн салбарын хамтын ажиллагаа гараагаа эхэлсэн үетэй холбон үзэх нь зүйтэй болов уу. Манай улсад Япон Улсын буцалтгүй хөрөнгийн тусламжаар ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах Говь үйлдвэр баригдаж, ашиглалтад орсон нь японы аж үйлдвэрийн соёл нэвтэрч, манай улсын эдийн засагт үр дүнгээ үзүүлэх анхны алхам болсон юм. Энэ үйлдвэр 1981 онд ашиглалтад орсноор Японы дэвшилтэт техник технологи орж ирсэн. Улмаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд японы туршлагаас нэвтрүүлж, мэргэжлийн инженер техникийн ажилтнаа Япон Улсад бэлтгэсэн. Удалгүй энэ үйлдвэр манай улсад ямааны ноолуур, тэмээний ноосон бүтээгдэхүүний чанар, дизайны цоо шинэ шийдлийг бий болгож, дэлхийн шилдэг 5 үйлдвэрийн нэгэнд орох болсон.

Говь компани богино хугацаанд Монгол Улсын төсвийн орлогын 30 гаруй хувийг бүрдүүлдэг чухал аж ахуйн газар болон хөгжиж, "1998 оны жилийн үйлдвэрлэлийн хэмжээ нь 1000 тн ноолуур, 200 тн тэмээний ноос, 68 тн сарлагийн хөөвөр, 120 тн ээрмэл, 40 мянган ширхэг ноолууран сүлжмэл бүтээгдэхүүн, 120 мянган м гаруй ноосон нэхмэл үйлдвэрлэх

болж, улсын төсөвт оруулах орлогын хэмжээ нь 50-60 тэрбум төгрөгт хүрчээ”². Мөн чөлөөт валютин орлогын 80 орчим хувийг Говь компани оруулж байжээ³.

Манай улсад ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбар, аж үйлдвэрийн нэгэн шинэ чиглэл болж үүсэн бэхжиж, Монгол Улс дэлхийн ноолуурын зах зээлд гол орны байр сууринд гарч чадсан юм. Гадаад худалдааны тодорхой хувийг ноолууран бүтээгдэхүүний экспорт эзлэх болж, өнөөдөр ч Итали, Япон, Европын зах зээлд борлуулагдах Монголын гол бараа болж байгаа. Энэ бүхэн бол японы аж үйлдвэрийн соёлын нөлөө, хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааны үр шим юм.

Улмаар 1990 оноос манай улсад ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоог нэвтрүүлсэн нь Япон Улстай тогтоосон эдийн засгийн хамтын ажиллагаа огцом хурдтайгаар өргөжин тэлэх боломж бүрдүүлж, Японы аж үйлдвэрийн арга туршлагаас суралцах, эдийн засгийг хөгжүүлэхэд Японы хүчин зүйлийг хэрэглэх чиглэлээр ахиц дэвшил гарахад тодорхой нөлөө үзүүлсэн юм.

Япон Улсын Засгийн газрын тусламж, Жайка-гийн шугамаар хэрэгжиж ирсэн Техникийн хамтын ажиллагаа, Иений хөнгөлөлттэй зээл, Буцалтгүй тусламж, Өвсний үндэс хөтөлбөрийн төслүүд нь манай улсын эдийн засгийн үйл ажиллагаа, бүс нутгийн хөгжлийн стратегийг дэмжих, аж үйлдвэрийг хөгжүүлэх, зах зээлийн үеийн хүний нөөцийг бэлтгэхэд чиглэж, нөгөө талаар японы үйлдвэрийн соёл, компанийн соёл, менежментээс суралцах боломжийг олгож ирсэн. Эдгээрээс заримыг дурдвал,

- Монгол-Японы Хүний нөөцийн хөгжлийн төв монголын бизнес эрхлэгчдэд зориулан Япон маягийн менежментийн танилцуулга, сургалтыг 2002 оноос зохион байгуулж, жижиг дунд болон бичил бизнес эрхлэгч, тэдгээрийн ажилтан албан хаагчид 5300 хүний мэргэжил мэдлэгийг дээшлүүлэн, бизнесийн менежментээ сайжруулахад нь дэмжлэг үзүүлжээ⁴.

- Хоёр талын инженер техникийн ажилтны солилцоо өргөн хүрээг хамран хэрэгжиж, Монгол Улс, Япон Улсын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрийн дүнд ЖАЙКА-гийн сайн дурын 2 гишүүн 1992 онд анх манай улсад томилогдон ирж ажиллаж байсан бол 2022 оны байдлаар 712⁵ сайн дурын инженер, техникийн ажилтнууд ирж, аж үйлдвэрийн хүний нөөцийг хөгжүүлэх, мэргэжлийн сургалт үйлчилгээ,

² Д.Салдан “Монгол, Японы эдийн засгийн хамтын ажиллагааг үүсгэн хэрэгжүүлсэн түүхэн зурвас (1973-1985)” УБ., 2008, 62-р тал

³ “Аж үйлдвэрээр овоглосон төрийн сайд П.Дамдин” УБ., 2010, 369-р тал

⁴ https://www.mn.emb-japan.go.jp/mn/bi_relation/econ_coop/odaintro_techcoop_mn.pdf

⁵ “Мөнгө, санхүү, баялаг” эдийн засгийн судалгаа шинжилгээний сэтгүүл, 2022 он, №31, х.68

хот орон нутгийн хөгжил, байгаль хамгаалал, дэд бүтцийн салбарт томилолтоор ажиллаж, японы компани, аж үйлдвэрийн үйл ажиллагааны арга туршлагыг танилцуулахад ихээхэн хувь нэмэр оруулсаар байна. Мөн манай улсаас удирдах болон төрөл бүрийн салбарын инженер техникийн ажилтан нарын нийтдээ 4000 гаруй хүн⁶ Япон дахь сургалтад хамрагдаж, аж үйлдвэр хөгжсөн орны үйлдвэр компаниудтай танилцаж, туршлага судалсан нь манай улсын хүний хөгжилд ихээхэн хувь нэмэр болсоор байна.

Манай улсад Японы аж үйлдвэрийн туршлагаас суралцаж, менежментийн тогтолцоондоо нэвтрүүлэн ажиллаж буй компаниудын тоо өссөөр байна. Тус Олон улс судлалын хүрээлэнгийн төлөвлөгөөт ажлын хүрээнд “Японы хөгжлийн туршлага /Японы менежмент, жижиг дунд үйлдвэр, хүний хөгжлийн бодлогын жишээн дээр/” төслийн судалгаа /2011-2013/ явагдаж байх үед бидний явуулсан судалгаагаар “НБЦ”, “Шилэн хийц” зэрэг компаниуд хүний нөөцийн үйл ажиллагаандаа ажилласан жилийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл, ажлын зэрэглэлийн үзүүлэлтийг оруулж япон маягийн менежментийн арга ажиллагаанаас нэвтрүүлэн, туршлагаа бусадтай хуваалцаж, тогтолцооны төлөвшилд нь ахиц дэвшил гарч байсан.

Мөн “Дархан хүнс”, “Хөгжил трейд” ХХК-ууд японы менежментийн 5S-ийн тогтолцоо буюу ажлын байрны эмх цэгц, нягт нямбай, цэвэр цэмцгэр байдал хийгээд дэг журам, сахилга баттай холбоотой туршлагыг нэвтрүүлж хэвшүүлэн үр дүнд хүрсэн байв⁷.

Монгол Улсаас Япон Улстай тогтоон хөгжүүлж буй Стратегийн түншлэлийн хүрээнд хоёр талын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг 2014 оноос эхлэн хэрэгжүүлж амжилттай дуусаад байна. 2017-2021 онд хэрэгжүүлсэн Стратегийн түншлэлийн дунд хугацааны 2 дахь хөтөлбөрт тусгагдсан хамтын ажиллагаа, тухайлан манай улсын эдийн засгийг төрөлжүүлэх, аж үйлдвэрийн хөгжлийг дэмжих, инженер технологийн хүний нөөц бэлтгэх чиглэлийн ажлууд нь хоёр орны аж үйлдвэрийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, манай улсад японы компанийн үйл ажиллагааны соёл нэвтэрч, үр дүнгээ өгөхөд чухал ач холбогдолтой хэмээн бодож байна. Үүнд,

Монгол Улсад өндөр мэдлэг, ур чадвар бүхий инженер, технологийн мэргэжилтэн бэлтгэх, инженерийн боловсролын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, багшлах боловсон хүчний нөөцийг бэхжүүлэх, сургалтын орчныг шинэчлэх, чанарыг сайжруулах зорилготой “Инженер, технологийн

⁶ https://www.jica.go.jp/mongolia/mon/office/others/c8h0vm00007dxgs4-att/training_mon.pdf

⁷ “Японы менежмент, жижиг дунд үйлдвэр: Хөгжлийн туршлага” ред. доктор /Ph.D/ Ц.Даваадорж, УБ., 2014, 52-53-р тал

дээд боловсрол" төсөл /2014-2023 он, 9 жил, 7,5 тэрбум иэний хөнгөлөлттэй зээл/-ийг дурдаж болно. Энэ төслийн хүрээнд "1000 инженер бэлтгэх хөтөлбөр" хэрэгжин, Япон улсад суралцаж бэлтгэгдсэн анхны инженерүүд Мобиком, МАК зэрэг компаниудад ажиллаж эхлээд байна.

Япон Улсын инженер, технологийн мэргэжлийн боловсрол олгох Коосэн сургалтын тогтолцоог Монгол Улсад нэвтрүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагаа хэрэгжиж, манай улсад одоогоор гурван Коосэн ажиллаж байна.

Манай улс 1998 оноос Японы үйлдвэрүүдэд ур чадварын дадлагажигч ажилтан ажиллуулж ирсэн. 2018 оны байдлаар 1154 монгол иргэн Япон Улсад үйлдвэрлэлийн дадлагажигчаар ажиллаж байна⁸. Энэ хамтын ажиллагаа нь монгол залуус Япон Улсын үйлдвэрлэлийн салбарт ажиллан технологи, мэдлэг туршлага хуримтлуулж, эзэмшсэн ур чадвар, мэдлэгээ өөрийн улсын үйлдвэрлэлийн салбарт нэвтрүүлэх боломжийг бүрдүүлж буй онцлогтой, зөвхөн хувь хүний мэдлэг чадвар, аж амьдрал төдийгүй улс орны эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлэх боломжтой чухал үйл ажиллагаа юм.

Одоогоор ХНХЯ-наас тусгай зөвшөөрөл олгосон 76 байгууллага дадлагажигч илгээх ажил хийж байна. Энэ 2019 оны дөрөвдүгээр сард "Ур чадвартай ажиллах хүчний тогтолцооны зохистой ажиллагааны үндсэн хүрээг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны санамж бичиг" байгуулсан. Монгол иргэдийн Японд хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, цалин хөлс, нийгмийн халамжид хамрагдах зэрэг хууль ёсны эрхийг энэхүү Санамж бичгээр бүрдүүлж өгчээ.

Японы хөрөнгө оруулалттай компаниуд 1990-ээд оноос хойш голдуу мэдээлэл харилцаа холбоо, хөнгөн хүнсний үйлдвэр, худалдаа нийтийн хоол, банк санхүү, боловсрол, аялал жуулчлал, барилга зэрэг салбарт үүсэн үйл ажиллагаа явуулж ирсэн.

Дээр дурдаж буй хамтын ажиллагааны хэдэн жишээнээс японы аж үйлдвэрийн соёлоос суралцах боломж бүрдэж байна, суралцах үйл явцын эхлэл тавигдаж байна гэж үзэх боломжтой.

Орчин үед манай улсад Японы аж үйлдвэрийн соёлоос суралцах шаардлага улам өсч байна. Үүнийг манай улсын эдийн засгийн өнөөгийн байдал, үндэсний үйлдвэрлэлийн хөгжлийн түвшин, уул уурхайгаас хамаарах хамаарал гүнзгийрч ашигт малтмал, газрын баялгийг боловсруулах хэрэгцээ тулгамдаж байгаа зэрэг олон хүчин зүйлтэй холбож үзэж болно.

Хоёр улсын стратегийн түншлэлийн харилцааг бэхжүүлэх хүрээнд байгуулагдсан "Монгол, Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр"-

⁸ <http://mlsp.gov.mn/nnews/487>

ийг хэрэгжүүлэхэд ч японы аж үйлдвэрийн соёлоос суралцаж, нэвтрүүлэх явдал чухал шаардлагатай байх нь тодорхой. Тус хэлэлцээрийг манайд чөлөөт худалдааны талаас нь, худалдааны хэмжээ өсөх талаас нь тайлбарлах явдал хэвлэл мэдээллээр түлхүү дамжуулж ирсэн мэт бодогддог. Харин Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн агуулгыг бүхэлд нь манай улсад эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх, тухайлбал манай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд түлхэц өгөх талаас нь авч үзэх нь чухал санагдана. Өөрөөр хэлбэл энэ хэлэлцээрийн хэрэгжилт нь юуны өмнө манай улсын эдийн засгийн өнөөгийн байдал, тухайлбал нэгд, уул уурхайн салбар голлох хандлага, үндэсний үйлдвэрлэлийн хөгжлийн хоцрогдол, экспортын бүтээгдэхүүний нэр төрөл цөөн, нэмүү өртөг байхгүй зэрэг эрсдэлтэй байдал, хоёрт, гадаад худалдаа хөрш орны зах зээлээс хэт хамааралтай байгаа туйлширсан хандлагыг бууруулах, манай улсын эдийн засгийн бүтцийг өөрчлөн сайжруулах, эцсийн дүнд Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад нөлөөтэй хэмээн үзэж байна.

Японы аж үйлдвэрийн туршлага, соёлоос суралцах шаардлагатай холбогдуулан, Монгол-Японы худалдааны хэмжээ сүүлийн хэдэн жилд хэрхэн өөрчлөгдөж байгааг товч авч үзье.

Хүснэгт. Монгол-Японы худалдаа сая ам.долл.

Он	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Монгол Улсын экспорт	5.6	10.5	24.5	20.3	14.0	14.8	26.5	15.5	9.7	16.1
Монгол Улсын импорт	501.6	444.2	367.8	274.6	330.6	363.2	561.0	585.5	406.7	453.1

Эх сурвалж: <http://customs.gov.mn/statistics>

Япон Улстай сүүлийн жилүүдэд хийсэн худалдааны үзүүлэлтийг харахад худалдааны алдагдал маш их, манай экспортын хэмжээ өсөөгүй байгаа нь анхаарал татна. Хоёр талын худалдаанд манай улсын экспортын эзлэх хэмжээ хэтэрхий доогуур байдал зөвхөн Япон Улстай хийж буй худалдаа төдийгүй, бусад улс дээр ч ижил байгаа нь манай экспортын барааны нэр төрөл цөөн, өрсөлдөх чадвар сул, өөрөөр хэлбэл олон улсын стандартыг хангах бүтээгдэхүүн байхгүй, түүнийг үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэл хөгжиж чадахгүй байгаатай холбоотой.

Одоогоор манай улсын тодорхой аж ахуйн нэгжүүд уламжлалт ноос ноолууран эдлэл зэрэг мал аж ахуйн; давс, архи, бяслаг, чацаргана, зөгийн

бал зэрэг хүнсний; цөөн тооны уул уурхайн бүтээгдэхүүн; мөн гар урлалын зарим зүйлс төдийхнийг Япон Улсад экспортолж байна. Түншлэлийн хэлэлцээр хэрэгжиж эхэлснээс хойш хөнгөн цагаан бүтээгдэхүүн, нөмрөг алчуур, сүлжмэл эдлэл зэрэг бүтээгдэхүүнээр экспортын нэр төрөл нэмэгдэж, зарим компанийн салбар дэлгүүр Японд нээгдэж, зах зээлд нь нэвтрэх эхлэл хийгдэж байна. Харин Япон Улсаас суудлын автомашин болон дагалдах хэрэгсэл, уул уурхай, барилгын машин механизм, цахилгаан бараа, холбооны техник хэрэгсэл, эрүүл мэндийн төхөөрөмж, эм, гоо сайхны бараа, тамхи, цагаан будаа, архи, цуу, гэр ахуйн бараа зэргийг нийлүүлж байна.

Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт 2021 онд 16 тэрбум ам.долл. байсны дотор гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 63.1%-ийг БНХАУ, 28.6%-ийг ОХУ тус тус эзэлж буйгаас үзэхэд Монгол Улсын экспортод аж үйлдвэрийн барааны хувь хэмжээг нэмэгдүүлэх, түүний дотор Эдийн засгийн түншлэлийн харилцаатай Япон Улс руу гаргах экспортын хэмжээг өсгөх, худалдааны алдагдлыг бууруулах, манай улсын гадаад худалдааны нийт эргэлтэд Япон Улстай хийх худалдааны хувь хэмжээг дээшлүүлэх шаардлага тулгамдаж байна. Үүнийг шийдвэрлэх нэг арга нь Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн боломжийг бүрэн ашиглах явдал болно.

2014 оны 7 дугаар сард Монгол Улс, Япон Улсын хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээ тохиролцоонд хүрсэнтэй холбогдуулан нийтэлсэн Хамтарсан мэдэгдэлд “Энэхүү Хэлэлцээр нь хоёр улсын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө оруулалт болон иргэдийн солилцоог нэмэгдүүлж, бие биеэ харилцан нөхсөн эдийн засгийн харилцааг цоо шинэ шатанд гаргана”¹⁰ гэдгийг цохон тэмдэглэсэн.

Япон Улсын Ерөнхий сайд Ш.Абэ “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр” байгуулах хэлэлцээ зарчмын тохиролцоонд хүрсэнтэй холбогдуулан Япон болон бусад улсад экспортлох Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, тоо хэмжээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Монголын экспортыг нэмэгдүүлэх, аж үйлдвэрийг төрөлжүүлэх зорилго бүхий Эрч нэмэх санаачилга” дэвшүүлсэн.

“Эрч нэмэх” санаачилгад Япон Улсын Засгийн газраас Монголын экспортыг нэмэгдүүлж, аж үйлдвэрийг төрөлжүүлэхийн тулд Монголын худалдаа, хөрөнгө оруулалтын орчныг ил тод, тогтвортой болгон урьдчилан таамаглагдах нөхцөл боломжийг дээшлүүлэх арга хэмжээ

⁹ <https://www.1212.mn/>

¹⁰ Монгол, Японы хооронд “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр” байгуулах хэлэлцээ зарчмын тохиролцоонд хүрсэн болон Япон Улс, Монгол Улсын хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тухай Хамтарсан Мэдэгдэл, Токио хот, 2014.07.22

авах, эдийн засгийн зөвлөх томилон ажиллуулах зэрэг Монголын эдийн засгийн урт, дунд хугацааны бодлого төлөвлөлтийг дэмжих; Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг үр дүнтэй ашиглуулахын тулд боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх; Тэргүүлэх чиглэлийн аж үйлдвэр, тухайлан хөдөө аж ахуй болон уул уурхайн салбараас үйлдвэрлэн гаргах бүтээгдэхүүний нэмүү өртгийг нэмэгдүүлэх, Монгол Улсын эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхийн тулд Монголын нөөц бололцоог ашиглан аж үйлдвэрийг төрөлжүүлж, уул уурхайн хамаарлаас салах зайлшгүй шаардлагатай холбогдуулан хөдөө аж ахуй, уул уурхайн салбарт үндэслэсэн шинэ аж үйлдвэрийн салбар, мөн аялал жуулчлал, банк санхүү, эрчим хүч болон мэдээллийн технологийн салбарыг голлон дэмжлэг үзүүлж, хамтын ажиллагаа хэрэгжүүлэх¹¹ заалтыг тусгасан.

2017 оны 3 дугаар сард байгуулагдан хэрэгжиж дууссан “Монгол, Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2021)”-т Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааны хүрээнд “Япон Улсын Засгийн газар Монгол Улсын инженер, технологийн дээд боловсролын байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, Япон Улсад оюутан сургах, Монгол, Японы хүний нөөцийн хөгжлийн төвөөр дамжуулан аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. Түүнчлэн мэргэжлийн бүхий л салбар дахь хүний нөөцийг хөгжүүлэх үүднээс мэргэжлийн боловсрол, сургалтын хугацаанд суралцагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн... дэмжлэг үзүүлнэ” хэмээн заасан.

Мөн Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр нь олон салбарын өргөн хамтын ажиллагааны боломжийг бүрдүүлж, 15 дугаар бүлэгт “хөдөө аж ахуй, ойн болон загасны аж ахуй, аж үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа хөрөнгө оруулалт, дэд бүтэц барилга хот байгуулалт, шинжлэх ухаан технологи болон оюуны өмч, санхүүгийн үйлчилгээ, боловсрол болон хүний нөөцийн хөгжил, аялал жуулчлал, байгаль орчин, уул уурхай болон эрчим хүч, эрүүл мэнд, өрсөлдөөн, мэдээлэл харилцаа холбооны технологи, талуудын Засгийн газар харилцан тохиролцсон бусад салбар”¹² хэмээн тодорхойлсон.

Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хэрэгжилтийг дэмжих зорилго бүхий дээр дурдсан Эрч нэмэх санаачилга болон “Монгол, Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2021)” нь манай улсын эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх, аж үйлдвэрийг төрөлжүүлэх, үндэсний жижиг дунд үйлдвэрийг дэмжих, олон улсын стандартын шаардлагад нийцсэн экспортын бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргахад

¹¹ Монголын экспортыг нэмэгдүүлэх, аж үйлдвэрийг төрөлжүүлэх зорилго бүхий Эрч нэмэх санаачилга, Токио, 2014.07.22

¹² Монгол, Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, 15 дугаар бүлэг, 1 дүгээр зүйл

чиглэсэн боломж бололцоог олгож байна. Гагцхүү манай талаас идэвх санаачилгатай байж, боломжийг бүрэн ашиглахад хүчин чармайлт гаргах шаардлага улам бүр тулгамдаж байна. Тодруулан хэлбэл, эдгээр боломжийг ашиглаж өөрийн улсад аж үйлдвэр хөгжүүлэх, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг зохистойгоор хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх урьдач нөхцөлүүдийн нэг нь Японы аж үйлдвэрийн соёл, менежментийн арга барилаас судлах, суралцах явдал гэж үзэж байна.

Аж үйлдвэрийн соёл гэх ойлголтод ерөнхийдөө төлөвлөлтөөс эхлээд зохион байгуулалт, үйлдвэрлэлт, нийлүүлэлт, нийлүүлэлтийн дараах үйлчилгээг хамруулан бүхэл цогц, өргөн хүрээтэй агуулга багтана. Мөн тухайн компанийн үндсэн философи, үйл ажиллагааны хөтөлбөртэй холбоотой /企業理念、経営理念、行動基準/ ойлголтууд /үйлдвэрийн философи/ багтдаг аж. Эдгээрээс япон маягийн менежмент хэмээн нэрд гарсан арга туршлагаас, тухайлбал компанид ажилд авсан боловсон хүчнийг насан туршид нь ажиллуулдаг /終身雇用制/, ажилласан жилийн эрэмбээр тушаал дэвшүүлдэг, цалин олгодог /年功序列制/, багийн ажиллагааг эрхэмд үздэг /チームワーク/ туршлага болон үйлдвэрүүдийн хамтын ажиллагаанд мөрдлөгө болгодог яг цагт нь үйлдвэрлэх, нийлүүлэх тогтолцоо /Just in time/, гэрээт үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны тогтолцоо /系列制/, чанарт хяналт тавьдаг тогтолцоо /品質管理制/ зэргээс сурч судлах, нутагшуулан хэрэглэх шаардлага тулгамдаж байна.

Компани ажилтан хүнийг ашиг олох хэрэгсэл, үйлдвэрийн газрын жижиг эд эс төдийгөөр үзэх биш, гэр бүлийн бүрэн эрхт гишүүн, тухайн үйлдвэр компани өсөн дэвжихийн гол эх үндэс, ажиллах хүчнийг эрхэм баялаг гэж үздэг, ажилтан хүний хувьд ч бүх хүч чадал, туршлагаа компанийн төлөө зориулж, аж амьдрал ар гэр нь баталгаатай байж чаддаг зарчмыг анхааран судалж, үлгэр дууриал авах явдал чухал болоод байна.

Хувь хүний хүчин зүйлээс компаний хөгжил хамаардаг, компанийн хөгжил салбарын хөгжилд нөлөөлдөг, салбарын хөгжлөөс улсын эдийн засаг хамаардаг гинжин тогтолцооны үйл явцад үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх япон менежмент улам бүр хөгжин гүнзгийрч ирсэн онцлогтой.

Байгуулагдан үйл ажиллагаагаа эхлээд буй Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежментийн төслийг хэрэгжүүлэх хоёр талын хамтарсан компани, мөн Монгол, Японы сургалтын эмнэлэг зэрэг том бүтээн байгуулалтын хамтын ажиллагаа нь манай улсад японы менежмент, ажлын арга барилаас суралцах онцгой боломжийг бий болгож байна.

Япон Улсын аж үйлдвэрийн соёл нь Азийн улс орнууд төдийгүй өрнөдийн орнуудад ч нэвтэрч хэрэглэгдэн, эдийн засгийн хөгжилд нь түлхэц болсоор ирснийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрдөг. Өнгөрсөн

зууны 70-аад оноос Азийн бар, Азийн шинээр аж үйлдвэржсэн орон бүс нутгууд гэгдэх Өмнөд Солонгос, Сингапур, Тайван, Хонг-конг, 80-аад оноос АСЕАН-ы улсууд гэх 10-аад орон, 90-ээд оноос Азийн социалист улсууд Хятад, Вьетнам зэрэг нь эдийн засгийн бүтээн байгуулалтдаа Японы хөгжлийн загвар, японы хүчин зүйлийг ашиглаж, тогтвортой хөгжлөө хэдэн арван жилээр үргэлжлүүлж чадаж байна. Хятад, Солонгос болон бусад улсад өнөөдөр ч Японоос суралцах хандлага буураагүй. Японы аж үйлдвэрийн соёлыг тал бүрээс нь судалсан маш олон судалгааны бүтээл гарсаар байна.

Японы эдийн засгийн өсөлт сүүлийн үед удаашралтай байгаа ч бусад улс орнууд аж үйлдвэрийн тогтвортой хөгжилд тус болох хамгийн ойрын үлгэр жишээ бол Япон гэж үзэж, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн чиг хандлагыг нь ажиглаж, түүнээс суралцаж байна. Жишээ нь өнөө үед Японы эдийн засагт ногоон чиглэлээр бүтцийн өөрчлөлт явагдаж, мэдээлэл холбооны технологи (ICT), эрчим хүчний шинэ эх үүсвэр, ногоон эрчим хүчний ашиглалт, хүн амын бууралт, ажиллах хүчний хандлагад зохицсон хүний оролцоо багатай автоматжуулсан үйлдвэрлэл, дижитал эдийн засгийн чиглэл рүү хөгжиж байна. Японы мэдээлэл холбооны технологийн болон дээр дурдсан салбаруудад ажиллаж байгаа Өмнөд Солонгос, Хятад Зүүн өмнөд Азийн зэрэг орнуудын иргэдийн тоо жилээс жилд өсч байна. Ялангуяа робот, компьютер, хиймэл оюун /人工知能 (AI)/ гэсэн аж үйлдвэрийн 4 дэх салбарт ажиллах хүсэлтэй гадаадын иргэдийн тоо олширсоор байна.

Дүгнэлт

Японы аж үйлдвэрийн соёлоос суралцаж нэвтрүүлэх нь

- Манай улсын үндэсний үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтөд нөлөөлнө. Ард түмний аж амьдралын түвшин дээшлэхэд ач холбогдолтой.
- Үндэсний үйлдвэрлэлийн хөгжил, үйлдвэрийн төрөлжилт нь гадаад худалдааны тэнцэл бий болоход нөлөөлнө. Үүний тулд, өнөөг хүртэл хэрэгжиж ирсэн Монгол, Японы эдийн засгийн хамтын ажиллагааны суурь дэвсгэр дээр түшиглэн Японы аж үйлдвэрийн соёлоос суралцаж, Монгол, Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг бодитойгоор хэрэгжүүлж жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй.
- Харин Японы соёлоос суралцахдаа шууд хуулбарлах бус, өөрийн орны түүх соёл, зан заншил, уламжлал, өөрийн үнэт зүйл, онцлогийг харгалзан үзсэний үндсэн дээр авч ашиглах, Азийн бусад улс орнуудад нэвтрүүлж хөгжилд хүрсэн туршлагыг ч хамтад нь

авч үзэх шаардлага бий. Ингэхдээ ул суурьтай, гүнзгий судалгаа явуулах, оновчтой зөв сонгол хийх, зохистой үед, зохистой хугацаанд үйл ажиллагаандаа нэвтрүүлэн нутагшуулах, бүрэн эзэмшиж үр дүнд хүрэх, эдгээрт суурилан урт хугацааны тогтвортой хөгжлийн суурийг бүрдүүлэх гэх мэт цогц шинжтэй, тасралтгүй тууштай үйл ажиллагааны үр дүнд амжилтад хүрэх болов уу.

Ашигласан материал

1. Монгол Улсын статистикийн эмхэтгэл /2012-2020 оны эмхэтгэлүүд/
2. Монгол, Японы хооронд “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр” байгуулах хэлэлцээ зарчмын тохиролцоонд хүрсэн болон Япон Улс, Монгол Улсын хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тухай Хамтарсан Мэдэгдэл, Токио хот, 2014.07.22
3. Монголын экспортыг нэмэгдүүлэх, аж үйлдвэрийг төрөлжүүлэх зорилго бүхий Эрч нэмэх санаачилга, Токио, 2014.07.22
4. Монгол, Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, 15 дугаар бүлэг, 1 дүгээр зүйл
5. “Монгол, Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2021)”
6. “Монголд хувь хүн маш мундаг, Японд багаараа чадвараа хөгжүүлдэг” Япон Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд М.Такаока-тай хийсэн ярилцлага zaluu.com.2018.10.18
7. Д.Салдан “Монгол, Японы эдийн засгийн хамтын ажиллагааг үүсгэн хэрэгжүүлсэн түүхэн зурвас (1973-1985) ” УБ., 2008, 62-р тал
8. “Аж үйлдвэрээр овоглосон төрийн сайд П.Дамдин” УБ., 2010, 369-р тал
9. “Японы менежмент, жижиг дунд үйлдвэр: хөгжлийн туршлага” ред. доктор /Ph.D/ Ц.Даваадорж, “Тод бичиг” хэвлэлийн компани, УБ., 2014
10. “Мөнгө, санхүү, баялаг” эдийн засгийн судалгаа шинжилгээний сэтгүүл, 2022 он, №31
11. <https://www.1212.mn/>

12. https://www.mn.emb-japan.go.jp/mn/bi_relation/econ_coop/odaintro_techcoop_mn.pdf
13. https://www.jica.go.jp/mongolia/mon/office/others/c8h0vm00007dxgs4-att/training_mon.pdf
14. http://open_jicareport.jica.go.jp/pdf/12284618.pdf
15. <http://mlsp.gov.mn/nnews/487>
16. www.econ.tohoku.ac.jp/~takaura/08yoshihiro.pdf#search=日本の企業文化
17. www.jstage.jst.go.jp/article/jasmine/中国と日本の企業文化の比較